



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№160 /374/

2022.09.09

Цаг үе, үйл явдал

МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм генерал, офицер, ахлагч, сонсогч, түрүүч, байлдагч, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэндээ орчин цагийн Зэвсэгт хүчинд Хуягт танкийн цэрэг үүсэж хөгжсөний түүхт 79 жилийн ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын орчин цагийн Зэвсэгт хүчний түүхийн бүхий л үе шатанд Хуягт танкийн мэргэжлийн бие бүрэлдэхүүний гүйцэтгэсэн үүрэг асар их бөгөөд өнөө цагт бие бүрэлдэхүүнийхээ мэргэжлийн дадлага, ур чадварыг нэмэгдүүлж, цэргийн сургалт бэлтгэлийг эрчимжүүлэн, олон улсын уралдаан тэмцээн, сургалт, дадлагад амжилттай оролцож, улс орны бүтээн байгуулалт, даян дэлхийн энхийн үйлсэд идэвхийлэн зүтгэж буйг баярын энэ өдөр онцлон тэмдэглэе.

Та бүхнийхээ цаашдын ажил үйлсэд арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөөе.

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь ямагт мандан бадрах бадартугай.

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН
ШТАБЫН ДАРГА
ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ**



Эрхэм, Монголын танкчин генерал, офицер, ахлагч, сонсогч, ажилтан нар аа.

Төрөлх Монгол орныхоо уудам сайханд, нутаг усандаа аж төрөн суугаа ахмад танкчин дайчид аа!

Та бүхэндээ, Монгол Улсад хуягт танкийн цэргийг үүсгэн байгуулсны 78 жилийн ойн баярын мэндчилгээг, Монголын танкчидын холбооны нэрийн өмнөөс дэвшүүлж, эрүүл энх, аз хийморь, амжилт ялалт бүхнийг хүсэн ерөөж байна.

Монгол Ардын Хувьсгалт цэргийн бүтцэд 1943 оны 9 дүгээр сарын 9-нд анх байгуулагдсан байлдааны салбар болох "Танкийн тусгай рот"-оос эхлэлтэй манай хуягт танкийн цэргийн 80 шахам жилийн түүхэн замнал үнэхээр бахдам бөгөөд цэрэг эрсийн бахархал болсоор ирсэн билээ.

Монголын танкчид Дэлхийн II дайны төгсгөлөөр, "Чөлөөлөх дайн"-ы

**"МОНГОЛЫН ТАНКЧИДЫН ХОЛБОО"-НЫ ТЭРГҮҮН,
ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР,
ЧӨЛӨӨНД БАЙГАА ХОШУУЧ ГЕНЕРАЛ Б.ЭРДЭНЭБАТ**

ялалтад оруулсан бодит хувь нэмрийг зөвхөн Монгол, Зөвлөлт, Хятадын ард түмэн төдийгүй Ази тив даяар мэдэж байдгийг түүх гэрчилнэ.

Тэртээ үед Монголын танкчид, байгаль цаг уурын, газар орны хүнд бэрх нөхцөл бүхнийг даван туулж, Халх гол, Хянганы их нурууг гаталж, фронтын шугам дээр дайсантай зах нийлсэн нөхцөлд байлдаж явсан баатарлаг түүхтэйг бид мэднэ.

XXI зуунд Монголын танкчид, зэвсэг нэгт бусад нөхдийн хамтаар "Олон улсын энхийг дэмжих ажиллагаа"-нд НҮБ-ын мандат дор хариуцлагатай, идэвх зүтгэлтэй оролцож эх орны нэр хүндийг өндөрт өргөж яваа төдийгүй, мэргэжлийн цэргийн Олон улсын хэмжээний "Танкийн биатлон" тэмцээнд амжилттай оролцож өндөр чансаа, мэргэжлийн их ур чадвараа гайхуулж Монголын хуягт танкийн цэргийг хөгжүүлж бэхжүүлэх үйлст ба эх орны бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж байгаа.

Танкчин та бид, ахмад, дунд үе болон бидний залуу халаа болсон сонсогч, сурагчдын амин холбоог, мэргэжлийн залгамж чанарыг, дайчин уламжлалаа хадгалж арвижуулахын төлөө ажиллаж байна. Цаашид ч эх орондоо чадах бүхнээ зориулах болно.

Монголын танкчидын түүхэн замнал, мятаршгүй зүтгэл, мэргэжлийн их чадвар улам батжиг, байлдааны болон техникийн бэлэн байдал байнга өндөрт байг, хуягт танкийн цэргийн сүр сүлд мандан бадраг.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.193.00	3.198.0
EUR 🇪🇺	3.263.0	3.280.0
CNY 🇨🇳	474.00	477.00
RUB 🇷🇺	48.50	49.50
JPY 🇯🇵	23.75	24.00
KRW 🇰🇷	2.41	2.43

ЗУРХАЙ



2022.09.09 /БААСАН ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 14

**НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ
САРЫН ГУРВАН ХӨХӨГЧИН
ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:
Эд мал арвидна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.21-19.18
БАРИЛДЛАГА:
ШИД
ШҮТЭЭН БАРИЛДЛАГА:
САНСАР

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр аливаа үйлс сэтгэлчлэн бүтнэ. Шүтээн босгох, хот балгадыг барих, тариа тарих, худалдаа наймаа хийх, шид бүтээл үйлдэх тарни тоолох болон дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн болой, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно.

“АЛСЫН ХАРАА 2050” СУРГАЛТ БОЛЖ БАЙНА

Монгол Улсын Засгийн газар болон Удирдлагын академи хамтран “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг сурталчлан таниулах ажлын хүрээнд зохион байгуулж буй хоёр өдрийн сургалтад БХЯ-ны холбогдох албан тушаалтнууд хамрагдаж байна. Тус сургалтаар “Шинэ сэргэлтийн бодлого” болон “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хоорондын уялдаа холбоо, цаашдын зорилго төлөвлөгөө, үнэлгээний талаар таниулах юм.

“Алсын Хараа-2050” хөтөлбөр нь Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Сайн засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүсчилсэн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн суурь 9 зорилго 50 зорилттой бөгөөд 10 жилээр буюу 2020-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттай хэрэгжих аж.

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хувьд “Амар тайван аюулгүй нийгэм”-ийг цогцлооход түлхүү анхаарч ажиллах юм.



**КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол

Нийт: 582,373,933

Эдгэрсэн

Нийт: 552,651,454

Нас барсан

Нийт: 6,419,951

Цахим шууданд

“ЯРИХ, ИЛТГЭХ УРЛАГ” СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн Офицер, ахлагч, түрүүч, байлдагч нарын хувь хүний хөгжил, манлайллыг сайжруулах зорилгоор ярих, илтгэх урлаг сэдвээр сургалт зохион байгууллаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын эрх бүхий “Эйл Эй энд си

ХХК,” “Их үйлсийн бүтээмж” ТББ-ын дэргэдэх “Хос төв” хөдөлмөрийн биржтэй хамтран Зэвсэгт хүчний Жанжин штабаас зохион байгуулсан тус сургалт нь цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, бие хүний онцлог, өгөгдөл, төрмөл

авьяас чадварыг үнэлэх, ажил мэргэжлийн зөв сонголт, эерэг харилцаа, эрүүл амьдралын тогтолцоог бүрдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой байлаа. Энэхүү сургалт нь 2022 оны 09 дүгээр сараас эхлэн 2023 оны 02 дугаар сарыг дуустал сард 2 удаагийн давтамжтайгаар явагдах юм.

Ахлагч Б.Золзаяа

Сургамжит өгүүлэл

Нэгэн аав өдөржин машин угаалгын газар машин угаачихаад сунаж унах шахан гэртээ иртэл охин нь халуун хоол хийгээд тавьчихсан, гэрээ цэмцгийтэл цэвэрлэчихсэн хичээлээ хийгээд сууж байв. Дээрхи байдлыг хараад аав нь гайхсан ч ядарсандаа, халуун хоолоо идчихээд охиндоо баярлаад сууж байтал охиных нь ангийнх нь багш утасдаж

ч хичээлийг нь таслуулахгүйн тулд уурлан, уцаарлан байж арга буюу зөвшөөрч ирж авахаар болжээ. Орой болж аав нь ажил тарах болоогүй байхад менежерээсээ чөлөө авахаар ороход дургүйцэх нь битгий хэл өөдөөс нь “Та өнөөдөр эрт харьж амраад, маргааш өглөө эрт ирээрэй” гээд явуулав. Гайхсан

болохоор би сургуульдаа ирэхээс ч ичдэг. Надад кафед сууж, кофе ууж, зайрмаг идэх мөнгө байхгүй болохоор би хичээлээ тараад ангийнхаа охидуудтай нийлж чаддаггүй. Учир нь миний аав машин угаалгын газар машин угаадаг бага цалинтай ажилчин. Би сарын өмнө энэ сургуулиасаа гарч жирийн хүүхдүүдтэй, жирийн сургуульд явахыг гуйхад аав маш их уурласан. Би жирийн сургуульд явахын тулд аавыг авч өгч чадахгүй юм чинь гээд “I phone” авч өгөхгүй бол сургуульдаа явахгүй гэсэн. Гэтэл аав мань надад, намайг ганцхан сар хүлээвэл авч өгнө гээд хичээлээ таслахгүй, заавал онц сурах хэрэгтэй шүү гэсэн юм. Ингээд би өчигдөр амралтын өдөр байсан болохоор аавтайгаа хамтдаа үсчин орж үсийн засууль гэж бодоод аавынхаа ажил дээр нь очиж даргаас нь чөлөө гуйх гэтэл дарга нь надад хандан аавыг угаах ёстой машинуудаа түрүүлж дуусгаад галт тэрэгний буудал руу ачигч хийхээр явсан гэсэн. Ингээд би гэртээ ирээд баахан уйлж сууснаа аавыгаа ирэхэд нь халуун хоол хийгээд гэрээ цэвэрлэцэн байж бая гэж бодоод гэрээ цэвэрлэж байгаад аавынхаа шкафан дотор гадуур нь улаан туузаар ороосон хайрцагтай зүйл байхыг хараад сонирхоод үзтэл “I phone” байсаныг нь харсан юм.

Хэдий ч охиноо сургуулиас нь авахаар яаран гүйсээр сургууль дээр нь очжээ. Удсан ч үгүй дунд сургуулийн хичээлийн хонх чих дүнгэнэтэл жингэнэж охины ангийн хаалга онгойход хаалгаар гүйлдэн гарч ирсэн хүүхэд бүр түүнтэй мэндэлж, хүндлээд байгааг хараад өөрийн эрхгүй гайхшралд орон зогсов. Гэтэл охин нь ангиасаа гарч ирээд аавдаа үнсүүлчихээд багш тантай уулзана гэсэн би түрүүлээд гарж байя гээд ангийнхаа хүүхдүүдтэй гүйлдээд явчихав.

Охины ангийн багш түүнийг ангид урьж оруулаад охиных нь бичсэн “Үнэ цэнэ” гэсэн гарчигтай зохион бичлэгийг уншуулжээ. Охин нь ийн бичжээ.

Би өглөө болгон ангийнхаа хүүхдүүд шиг аав ээжийнхээ машинаар хүргүүлж сургуульдаа ирдэггүй. Автобусаар л ирдэг. Надад “I phone”, “I pad” байхгүй. Миний сольж өмсөх хувцас цөөхнийг манай ангийн хүүхдүүд мэддэг



охин нь хичээлээ тасласаныг хэлээд ирж уулзахыг хүсэв.

Цэвэрхэн гэр, халуун хоолны учрыг мэдсэн аав охиноо нүүр нүдгүй загнасан ч охин нь юу ч хэлсэнгүй. Маргааш өглөө нь хөөрхий аав том болсон охиноо дагуулаад сургууль руу нь хүргэж өгөхөд, өндөр төлбөртэй сургуулийн боломжтой айлын хүүхдүүд өнөөх өнгө нь гандсан хувцастай угагч аавыг хялам цэхэм хийж харж, охиныг нүүр хийх газаргүй болгожээ. Ийнхүү аав нь охиноо ангид нь оруулж өгөн багштай нь уулзчихаад ажилруугаа яаран явав.

Охин аавыгаа ангиас нь гарч явах гэхэд нь гүйж очоод өөрийг нь хичээл тарахаар заавал ангийнх нь үүднээс ирж авахыг захьжээ, хэрэв ирж авахгүй бол маргааш дахин хичээлээ таслана гэж сүрдүүлжээ. Ингээд аав нь өөрийнхөө өнгө нь гандсан хувцас, байгаа байдлаас ичиж, охиноо эвгүй байдалд оруулахаас санаа зовсон хэдий

ҮНЭ ЦЭНЭ

ОЛОН УЛСАД

МОНГОЛЫГ АНУ-ТАЙ ХАМТАРСАН ЦЭРГИЙН СУРГУУЛИЛТ ХИЙСНИЙГ БНСУ-ЫН ТАЛ САЙШААЖЭЭ



Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай 2022 оны есдүгээр сарын 6-8-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулсан Сөүлийн батлан хамгаалах яриа, хэлэлцээ уулзалтад оролцжээ.

Уулзалтын үеэр дэд сайд Б.Баярмагнай БНСУ-ын Батлан хамгаалахын дэд сайд Шин Бом Чол нар хоёр талын уулзалт хийсэн байна. БНСУ-ын Батлан хамгаалахын дэд сайд Шин Бом Чол хэлэхдээ НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Зэвсэгт хүчин, АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлалтай хамтран зохион байгуулсан “Хааны эрэлд-2022” хамтарсан сургуулилтад оролцсон явдлыг өндрөөр үнэлжээ.

Талууд хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэн, өргөжүүлэн хөгжүүлэх талаар санал солилцлоо.

Дэд сайд Б.Баярмагнай хариуд нь Монгол, Солонгос хоёр улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь Монгол Улсын Зэвсэгт хүчин, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. Мөн хэлэлцээний үеэр дэд сайд Б.Баярмагнай БНСУ-ын Батлан хамгаалахын сайд Ли Жун Собтой танилцах уулзалт хийж Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын мэндчилгээг уламжилжээ.

Түүнчлэн тэрбээр Канадын батлан хамгаалахын дэд сайдтай хоёр талын уулзалт хийж, хоёр улсын батлан хамгаалах салбарын цаашдын хамтын ажиллагааны талаар ярилцсан төдийгүй Унгар болон Камбож Улсын батлан хамгаалахын дэд сайд нар, АНУ, БНСУ-ын Хамтарсан командлалын

орлогч командлагч нартай танилцах уулзалт хийсэн байна. Сөүлийн батлан хамгаалах яриа, хэлэлцээ нь дэлхийн энх тайван, тогтвортой байдлын төлөөх олон талт аюулгүй байдлын батлан хамгаалахын дэд сайд болон судлаач, мэргэжилтнүүдийн түвшний яриа, хэлэлцээ юм.

Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчинд үнэлэлт, дүгнэлт хийх, олон талт яриа хэлэлцээг дэмжих, харилцан ойлголцол, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэсэн энэхүү уулзалт энэ жил 11 дэх удаагаа зохион байгуулагдаж байгаа бөгөөд нийт 48 улс, олон улсын 3 байгууллагаас дэд сайд болон эрдэмтэн, судлаачид оролцжээ. Энэ жилийн яриа, хэлэлцээ нь “Аюулгүй байдлын цогц сорилтуудыг хэрхэн шийдвэрлэх: Олон улсын эв санааны нэгдлийг дэмжих” гэсэн үндсэн сэдвийн хүрээнд явагдсан байна.

Эх сурвалж: Eguur.mn

Гэрэл зураг нэг-агшин

